БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-ИЙН
ДЭД ЗАХИРАЛ П.ГАНБОЛД

2025 оны .... дугаар сарын ....-ны өдөр

ОРОН НУТГИЙН НИСЭХ БУУДЛУУДЫН ШАТАХУУН ХАДГАЛАХ АГУУЛАХЫН САВНЫ ХАМГААЛАЛТЫН /БАЯН-ӨЛГИЙ, УВС, ЗАВХАН, ГОВЬ-АЛТАЙ, БАЯНХОНГОР/ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү ажлын даалгаварт агаарын хөлгийн шатахууны агуулахын бүтээгдэхүүн хадгалах хэвтээ савны дотор талын ханыг зориулалтын хамгаалалтын бүрхүүлд тавигдах шаардлага, бүрхүүлийн ажлын технологийн шаардлага, тоо хэмжээг тусгав.

СТАНДАРТЫН ШААРДЛАГА

- EI Standard 1541 Requirements for internal protective coating systems used in aviation fuel handling systems/

1. ХАМГААЛАЛТЫН БҮРХҮҮЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.1. Хамгаалалтын бүрхүүлд тавигдах стандарт шаардлага

Агаарын хөлгийн шатахууны хадгалах савны дотоод гадаргууг бүрхэх хамгаалалтын бүрхүүл нь шатахууны чанарт сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй ба үүнийг баталгаажуулахын тулд бүрхүүл нь дараах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудын аль нэгэнд нийцсэн байх ёстой.

- DEF STAN 80-97 Paint, system, for the interior of bulk fuel tank and fittings, two pack
- MIL-PRF-4556 Performance specification – Coating kit, epoxy, for interior of fuel tanks
- MIL-PRF-23236 Performance specification – Paint coating systems, fuel and salt water

1.2. Бүрхүүлд тавигдах нэмэлт шаардлага

- DEF STAN 80-97, MIL-PRF-4556, MIL-PRF-23236 стандартын шаардлагыг хангасан бүрхүүлүүдийн хувьд нэмэлтээр лабораторийн туршилт хийх шаардлагатай.
- Дээрх лабораторийн туршилтээр бүрхүүл нь агаарын хөлгийн шатахуунд хэрхэн нөлөөлөх, тэсвэрлэх зэргийг тодорхойлно.
- Туршилт нь EI Standard 1541 стандартын 2.2.1-д заасны дагуу лабораторын туршилтыг хийж, 2.2.2-д заасан үр дүнгийн шаардлагыг хангаж байж уг бүрхүүлэн хамгаалалт нь агаарын хөлгийн шатахуун хадгалах саванд ашиглах боломжтой гэж үзнэ.
- Агаарын хөлгийн шатахуун хадгалах саванд ашиглагдах бүрхүүл нь цагаан эсвэл цайвар енгөтэй байх шаардлагатай.
- Бүрхүүлийн гадаргуу нь толигор, гөлгөр байх шаардлагатай бөгөөд энэ нь ус зайлуулах нөхцлийг сайжруулна.
- Мөн EI Standard 1541 стандартын 3.2.1-т заасан туршилтыг хийж 3.2.2-т заасан шаардлагыг хангасан эсэх үр дүнг танилцуулах

2. ХАМГААЛАЛТЫН БҮРХҮҮЛИЙГ СОНГОХ, БЭЛТГЭХ ТҮРХЭХ БА ШАЛГАХ

- Хамгаалалтын бүрхүүлийн системийг зөв сонгох, гадаргууг бэлтгэх, бүрхүүлийг зөв түрхэх нь үр дүнтэй удаан эдэлгээтэй байх үндэс суурь болно.
- Бүрхүүл нь металл гадаргууг зэврэлтээс хамгаалах, шатахууныг бохирдлоос сэргийлэх, ус зайлуулах нөхцлийг сайжруулах, удаан эдэлгээтэй байх шаардлагатай.

3. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Гүйцэтгэгч нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн угсралт, үйлчилгээний туршлагатай байх
- Гүйцэтгэгч нь бүрхүүлийн үйлдвэрлэгчид шатахууны төрөл, орчны температур, ашиглалтын нөхцөл байдлын талаар мэдээллэж, үйлдвэрлэгчээс мэдээллийн дагуу тухайн бүрхүүл нь шаардлагыг хангаж байгааг баталгаажуулсан байна.
- Гүйцэтгэгч нь үйлдвэрлэгчээс бүрхүүлийн (Гадаргууг бэлтгэх, бүрхүүлийн зузаан, давхаргын тоо, түрхэх арга, шалгалтын арга г.м) зааварчилгааг авч дагаж, технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- Баталгааны хугацаанд гарсан гэмтлийн засварын ажлыг гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэх
- Агаарын хөлгийн шатахууны савны дотор бүрхүүлийн ашиглалт, засвар үйлчилгээний талаар захиалагчийн төлөөлөгчдийг сургалтанд хамруулах

4. ТОО ХЭМЖЭЭ

№	Нисэх буудлууд	Тоо хэмжээ
1	Баян-Өлгий аймгийн Өлгий	320 $м^2$ талбай буюу 75 $м^3$-ийн 4 ширхэг ил хэвтээ сав
2	Увс аймгийн Дэглийцагаан	120 $м^2$ талбай буюу 50 $м^3$-ийн 1 ширхэг, 25 $м^3$-ийн 2 ширхэг ил хэвтээ сав
3	Говь-Алтай аймгийн Алтай	120 $м^2$ талбай буюу 25 $м^3$-ийн 4 ширхэг ил хэвтээ сав
4	Завхан аймгийн Отгонтэнгэр	60 $м^2$ талбай буюу 25 $м^3$-ийн 2 ширхэг ил хэвтээ сав
5	Баянхонгор аймгийн Баянхонгор	60 $м^2$ талбай буюу 25 $м^3$-ийн 2 ширхэг далд хэвтээ сав

5. АЖИЛЛАХ НӨХЦӨЛ

№	Нисэх буудлууд	Савны тоо, хэмжээ	Тайлбар
1	Өлгий	75 $м^3$-ын 4 ширхэг	Ашиглагдаж байгаа, энгийн хуучин сав
2	Дэглий цагаан	50 $м^3$-ын 1 ширхэг, 25 $м^3$-ын 2 ширхэг	Ашиглагдаж байгаа, энгийн хуучин сав
3	Алтай	25 $м^3$-ын 4 ширхэг	Ашиглагдаж байгаа, энгийн хуучин сав
4	Отгонтэнгэр	25 $м^3$-ын 2 ширхэг	Ашиглагдаж байгаа, энгийн хуучин сав
5	Баянхонгор	25 $м^3$-ын 2 ширхэг	Ашиглагдаж байгаа, энгийн хуучин сав

Тус агуулахууд нь бүгд ашиглагдаж байгаа бөгөөд сав тус бүрд агаарын хөлгийн шатахуун хадгалагдаж байгаа тул бүх савыг нэг зэрэг суллаж, хамгаалалтын бүрхүүл хийх боломжгүй.

6. БУСАД НӨХЦӨЛ

- Ашиглалт болон засвар үйлчилгээний гарын авлага (Монгол хэл дээр) ирүүлэх

7. ХҮЛЭЭН АВАХ

ИНҮТ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авах актанд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүлээн авсанд тооцно.

Баталгаат хугацаа нь хүлээн авах актанд гарын үсэг зурж баталгаажсан хугацаанаас хойш гурваас доошгүй жил байна.

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮ ХАРИУЦСАН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Н.ЗОЛЖАРГАЛ

ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ШАТАХУУН ХАНГАЛТЫН
АЛБАНЫ ДАРГА Н.БАТТӨР

БОЛОВСРУУЛСАН:
ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ШАТАХУУН ХАНГАЛТЫН
АЛБАНЫ ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Б.ГАНТУЛГА